



САЙНЦАГААН СУМЫН 7-Р ЦЭЦЭРЛЭГ

Тус цэцэрлэгийг Дундговь аймгийн засаг даргын 2013 оны 11 сарын 20 ны А/ 580 тоот захирамжийн дагуу Сайнцагаан сумын 5-р багийн нутаг дэвсгэр болох 5 дугаар сургуулийн баруун талд канад модон технологиор 785.930.421 төгрөгийн төсөвт өртөгөөр барьж гүйцэтгэсэн. Манай цэцэрлэг нь 2 давхар, 4 бүлэгтэй, 100 хүүхдийн хүчин чадалтай, 7-р цэцэрлэг гэсэн нэршилтэйгээр байгуулагдаж 2013 оны 12-р сарын 22-нд 2-5 насны 130 хүүхэд, 1 эрхлэгч, 1 аргазүйч, 5 багш, 4 туслах багш, 9 үйлчилгээний ажилчидтайгаар үйл ажиллагаагаа эхлүүлж байсан түүхтэй.



Одоо тус цэцэрлэгийн 4 бүлэгт 170 хүүхэд сурч хөгжиж, 21 багш ажилтан ажиллаж бага насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож сургуульд бэлтгэн өгч байна. Жил бүр тойргийнхоо хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд 89-94%тай хамруулдаг. Мэргэжлийн багшаар 100% хангагдсан нийт багш нарын 71,4% мэргэжлийн зэрэгтэй. Мэргэжлийн багшаар 100% хангагдсан нийт багш нарын 71,4% мэргэжлийн зэрэгтэй. 2014 онд “Холимог бүлгийн аргазүйг” үйл ажиллагаандаа анх туршин хэрэгжүүлж арга туршлагаа бусад сумдын цэцэрлэгт

түгээн дэлгэрүүлж, аймаг болон улсын сайн хичээл зөвлөгөөний ийё ïðàèðèèèéí áààà òóðàèëà багш Л.Орхонтуул нь “Холимог бүлгийн аргазүй” сэдэвт илтгэл тавьж аймагтаа тэргүүн байр, улсад тусгай байр эзэлж тэргүүн туршлагаа түгээн дэлгэрүүлж ирсэн Манай хамт олны дундаас ажил хөдөлмөрөөрөө тэргүүний багш ажилчид олноор төрөн гарч байна. Үүнд цэцэрлэгийн аргазүйчээр ажиллаж байсан өндөр настан Г.Оюунчимэг, нярав Д.Уранчимэг, багш Ж.Ганчимэг, Л.Орхонтуул, С.Мөнхтунгалаг, нягтлан бодогч Н.Энхмарт, туслах багш О.Нарантуяа, жижүүр Ш.Мөнхбаяр нарыг дурьдаж байна.

Тус цэцэрлэгийн багш ажилчдаас Хөдөлмөрийн хүндэт тэмдгээр аргазүйч Г.Оюунчимэг, БТА- тэмдэгээр эрхлэгч Л.Дэлгэрмаа, багш Ж.Ганчимэг, Худалдаа үйлдвэрлэлийн тэргүүний ажилтан тэмдэгээр нярав Д.Уранчимэг нар тус тус төрөн гарсан.

Багш нараас тэргүүлэх зэрэгтэй багш -2 , Заах аргач зэрэгтэй багш -3 ажиллаж байна.

Манай хамт олон түүхэн хугацааны он жилүүдэд амжилт бүтээлээр арвин ажиллаж ирлээ.

Бидний гаргасан амжилтаас дурьдахад:

- 2014 онд :”Ажилд зуучлагчийг дэмжигч байгууллага”
- 2018 онд:” Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон” дэд байр
- 2018 онд: Мандалговь хотын “ОНЫ ЭКО БАЙГУУЛЛАГА”
- 2019 онд “ШИЛДЭГ БҮТЭЭЛЧ ХАМТ ОЛОН”
- 2019 онд: Сайнцагаан сумын засаг даргын 2019 оны үйл ажиллагааны”Сайнцагаан -95” дэд хөтөлбөрийн хүрээнд хотын өнгө үзэмж, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх зорилготой “Шилдэг тохижилт-гэрлэн чимэглэл” болзолт уралдаанд амжилттай оролцож ШИЛДГЭЭР шалгарсан
- 2021 онд МУГЖ Ц.Цэнд-Аюушийн нэрэмжит “ Бага тайз-2022” улсын нээлттэй уралдааны ГРАН ПРИ шагнал
- 2022 онд “Үндэсний бичиг үсэгтэн хамт олон” тэргүүн байр
- 2023 онд “Илтгэл -2023” уралдаанд багш нарын баг дэд байр



Манай цэцэрлэг нь хүүхэд тоглох, зохистой хооллох, амрах, өөрийгөө хөгжүүлэх, бие даан суралцах бүх талын нөхцөл бололцоо болон сургалтын материал хэрэглэглэхүүнээр хангагдсан. 4 бүлэгт 2-5 насны хүүхдүүдийг хөгжүүлж төлөвшүүлж байна.

Бид хүүхдэд дараах чадваруудыг эзэмшүүлэхээр зорин ажиллаж байна. Үүнд.

- ✚ Сурах урам зоригтой
- ✚ Өөртөө итгэлтэй
- ✚ Дүрэм журмыг ойлгодог хэрэгжүүлдэг
- ✚ Шинийг мэдэх эрмэлзэлтэй
- ✚ Хүнлэг, халамжтай, бусдыг хүндэтгэдэг
- ✚ Эелдэг дотно харилцаатай
- ✚ Дүрслэх урлаг, хөгжмийн мэдрэмжтэй
- ✚ Сонголт хийх чадвартай
- ✚ Анхаарлаа төвлөрүүлэх чадвартай
- ✚ Бүтээлч сэтгэлгээтэй



СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын СӨБ-ын сургалтын ЦӨМ хөтөлбөрийн хүрээнд өөрийн цэцэрлэгийн сурган хүмүүжүүлэх үзэл баримтлалд суурилан бага насны хүүхдийг тоглох явцад нь хөгжүүлэх сургалтын хөтөлбөрөө боловсруулсан.

2-5 насны хүүхдийн танин мэдэхүй, сэтгэхүйн хөгжлийг дэмжин хөгжүүлэх үйл ажиллагаа орохоос гадна 5-н төрлийн дугуйлан хичээллүүлж хүүхэд бүрийг дугуйланд хамруулан ажиллаж байна.



Хүүхдээ дээдлэн, багшаа хөгжүүлэх, сургалтын орчны стандартыг хангаж чанартай сургалт явуулахын тулд сургалтын аргазүй, технологийн шинэчлэл багш нарын заах аргазүйн шинэчлэлийн талаар Буриад улсын Улаан-Үүд хотын Журавленок цэцэрлэг, дотоодын 30, 138, 139-р цэцэрлэгүүдтэй түншлэлийн холбоотой хамтран ажиллаж харилцан туршлага солилцон ажилладаг.



Манай хамт олон цаашид СӨБ-ын “Цөм” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцдаа чанарын ахиц гарган, үйлчилгээндээ бүтээмжийн үйл ажиллагааг бүтээлчээр хэрэгжүүлэн ажиллаж суралцагч байгууллага болох зорилт тавин ажиллаж байна

Бидний амжилттай ажиллах гол үндэс нь өдөр тутмын жигд үйл ажиллагааг ханган ажиллаж, хүн бүр өөрийн хариуцсан ажилдаа эзэн нь байж чаддагт оршино гэж үздэг.